



**НИЙСЛЭЛИЙН СҮХБААТАР ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2021 оны 03 сарын 22 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12, 20.1.14 дэх заалтыг үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс Тогтоох нь:

1. Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шагнал түүнийг олгох шинэчилсэн журмыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг мөрдөж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Х.Болормаа/, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Д.Азжаргал/-д даалгасугай.
3. Тогтоол гарсантай холбогдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 22 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Б.ЭНХБОЛД



Сүхбаатар дүүргийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 03
дугаар сарын 22-ны өдрийн
10. дугаар тогтоолын хавсралт

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ШАГНАЛЫН ТӨРӨЛ ТҮҮНИЙГ ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Дүүргийн нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж, тодорхой амжилт гаргасан иргэн, аж ахуйн нэгж байгууллага, тэдгээрийн албан хаагчдыг шагнаж урамшуулахад энэхүү журмыг мөрдөнө.

ХОЁР. ШАГНАЛЫН ТӨРӨЛ

- 2.1. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын хамтарсан шагнал:
 - 2.1.1. “Хүндэт тэмдэг”
 - 2.1.2. “Хөдөлмөрийн алдар” медаль
- 2.2. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагнал:
 - 2.2.1. “Хүндэт иргэн”
 - 2.2.2. “Хурлын хүндэт тэмдэг”
 - 2.2.3. “Хүндэт өргөмжлөл”
- 2.3. Дүүргийн Засаг даргын шагнал:
 - 2.3.1. “Хүндэт өргөмжлөл”
 - 2.3.2. “Өргөмжлөл”
 - 2.3.3. “Шилдэг хүүхэд” медаль

ГУРАВ. ШАГНАЛД НЭР ДЭВШИГЧДЭД ТАВИГДАХ БОЛЗОЛ, ШААРДЛАГА

- 3.1. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын хамтарсан шагналд нэр дэвшигч нь дор дурдсан болзлыг хангасан байна. Үүнд:
 - 3.1.1. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжид 10-аас доошгүй жил үр бүтээл, идэвх санаачилгатай ажиллаж, хөдөлмөрийн амжилтаараа хамт олноо хошуучилсан иргэнийг “Хүндэт тэмдэг”-ээр шагнана.
 - 3.1.2. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжид 5-аас доошгүй жил үр бүтээлтэй ажиллаж, эрхэлсэн ажилдаа тодорхой амжилт гаргасан иргэнийг “Хөдөлмөрийн алдар” медалиар шагнана.
- 3.2. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналд нэр дэвшигч нь дор дурдсан болзлыг хангасан байна. Үүнд:
 - 3.2.1. Иргэдийн эрүүл мэнд, амь насыг хамгаалах, ая тухтай амьдрах орчин бий болгох, тэдгээрийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, шинэ технологи, шилдэг инноваци нэвтрүүлж, салбартаа ажил хөдөлмөрөөрөө тэргүүлсэн, дүүргээ хөгжүүлэх үйлсэд онцгой хувь нэмэр оруулсан, дүүрэгтээ 10-аас доошгүй жил амьдарсан иргэнд

- дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дээд шагнал “Хүндэт иргэн”-ээр шагнаана.
- 3.2.2. Дүүргийн нийгэм, эдийн засгийн хөгжил, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаанд бодитой хувь нэмэр оруулсан, шинийг санаачилж дүүргийн хөгжлийг шинэ шатанд гаргах бодитой үр нөлөө үзүүлсэн салбартаа 8-аас доошгүй жил ажилласан иргэнийг “Хурлын хүндэт тэмдэг”-ээр шагнаана.
- 3.2.3. Дүүргийн нийгэм, эдийн засгийн хөгжил, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаанд бодитой хувь нэмэр оруулсан, салбартаа 5-аас доошгүй жил ажилласан иргэнийг “Хүндэт өргөмжлөл”-өөр шагнаана. Мөн дүүргийн тэргүүний хамт олон, аж ахуйн нэгж байгууллагыг “Хүндэт өргөмжлөл”-өөр шагнаж болно.
- 3.3. Дүүргийн Засаг даргын шагналд нэр дэвшигч нь дор дурдсан болзлыг хангасан байна. Үүнд:
- 3.3.1. Дүүргийн бүтээн байгуулалт, хөгжил дэвшилд бодитой хувь нэмэр оруулсан төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж хамт олныг “Хүндэт өргөмжлөл”-өөр шагнаана.
- 3.3.2. Дүүргийн нийгэм эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулсан, салбартаа 3-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан иргэнийг дүүргийн Засаг даргын “Өргөмжлөл”-өөр шагнаана.
- 3.3.3. Мэдлэг боловсрол, авьяас чадвар, амжилт бүтээл, нийгмийн идэвхээрээ үе тэнгийн нөхөд, анги хамт олноо хошуучилсан хүүхдийг “Шилдэг хүүхэд” медалиар шагнаана.

ДӨРӨВ. ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ, ТОДОРХОЙЛОХ

- 4.1. Шагналд нэр дэвшигч нь энэ журмын 3 дугаар зүйлд заасан болзлыг хангасан байна.
- 4.2. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал болон Засаг даргын хамтарсан шагнал, Засаг даргын шагналд нэр дэвшигчийн холбогдох материалыг бүрдүүлэн дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтэст, дүүргийн Төлөөлөгчдийн Хурлын шагналд нэр дэвшигчийн материалыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албанд ирүүлнэ.
- 4.3. Материалыг хүлээн авсан хэлтэс, алба нь 30 хоногийн дотор шийдвэрлэж хариу өгнө.
- 4.4. Шагналыг тэмдэглэлт баяр ёслолыг тохиолдуулан эсвэл онцгой тохиолдолд гардуулна.
- 4.5. Шагналд нэр дэвшүүлэхэд дараах материалыг бүрдүүлнэ.
- А/ Анкет
 - Б/ Иргэний үнэмлэхийн хуулбар
 - В/ Байгууллага, аж ахуй нэгжийн дарга, захирал, эрхлэгчийн гарын үсэг, тамга, тэмдэг бүхий ажлын үр дүнгийн тодорхойлолт, шагнуулах үндэслэл /ажлын амжилтыг товч, тодорхой үнэн зөв тусгасан байх/
 - Г/ Хамт олны хурлын тэмдэглэл
 - Д/ Өмнө нь дүүргийн шагнал авч байсан бол үнэмлэхийн хуулбар
- 4.6. Дүүргийн шагнал хоорондын хугацаа 3-аас дээш жил байна. Онцгой гавьяа байгуулсан тохиолдолд энэ хугацаа хамаарахгүй.
- 4.7. Дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга болон Засаг дарга нь өөрийн санаачилгаар шагналд нэр дэвшүүлж болно.

**ТАВ. ШАГНАЛЫН МАТЕРИАЛЫГ ХҮЛЭЭН
АВЧ ШИЙДВЭРЛЭХ**

- 5.1. Шагналд нэр дэвшигчийн материалыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Ажлын алба, Засаг даргын Тамгын газрын шагнал хариуцсан ажилтан холбогдох журмын дагуу хүлээн авч боловсруулан, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Ажлын албаны дарга, Засаг даргын Тамгын газрын даргад хянуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга болон Засаг даргад тус тус танилцуулан шийдвэрлүүлнэ.
- 5.2. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Ажлын алба, Засаг даргын Тамгын газар нь бүрдэл дутуу материалыг хүлээн авахгүй.

**ЗУРГАА. ШАГНАЛД ДАГАЛДАХ МӨНГӨН
УРАМШУУЛАЛ, БАТАЛГАА**

- 6.1. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын хамтарсан шагнал:
 - 6.1.1. “Хүндэт тэмдэг” шагналаар шагнуулагчид баталгаа болгон Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг даргын гарын үсэг, тамгатай, хувийн дугаар бүхий үнэмлэх олгоно.
 - 6.1.2. “Хөдөлмөрийн алдар” медалиар шагнуулагчид баталгаа болгон Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг даргын гарын үсэг, тамгатай, хувийн дугаар бүхий үнэмлэх олгоно.
- 6.2. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагнал:
 - 6.2.1. “Хүндэт иргэн”-ийг 500,000 /Таван зуун мянга/-н төгрөгийн урамшуулал дагалдах бөгөөд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвөөс санхүүжүүлнэ.
 - 6.2.2. “Хүндэт иргэн” нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын гарын үсэг, тамга, хувийн дугаар бүхий байна.
 - 6.2.3. “Хурлын хүндэт тэмдэг” нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын гарын үсэг, тамга, хувийн дугаар бүхий үнэмлэх байна.
 - 6.2.4. “Хүндэт өргөмжлөл”-нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын гарын үсэг, тамга, хувийн дугаар бүхий байна.
 - 6.2.5. Дүүргийн бүтээн байгуулалт, хөгжил дэвшилд бодитой хувь нэмэр оруулсан гадаад улсын иргэнийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналаар шагнаж болно.
- 6.3. Дүүргийн Засаг даргын шагнал:
 - 6.3.1. “Хүндэт өргөмжлөл” нь Засаг даргын гарын үсэг, тамга, хувийн дугаар бүхий байна.
 - 6.3.2. “Өргөмжлөл” Засаг даргын гарын үсэг тамга, хувийн дугаар бүхий байна.
 - 6.3.3. “Шилдэг хүүхэд” медаль нь Засаг даргын гарын үсэг тамгатай, хувийн дугаар бүхий үнэмлэх олгоно.
- 6.4. Шагнал хийлгэх зардлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсөв, Засаг даргын нөөц сангаас санхүүжүүлнэ.
- 6.5. Шагналын дагалдах мөнгөн урамшууллыг шагналд нэр дэвшигчийг тодорхойлсон байгууллага хариуцна. Үүнд:
 - А/ Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын хамтарсан шагнал:
 - “Хүндэт тэмдэг” шагналыг 25,000 /Хорин таван мянга/ төгрөг
 - “Хөдөлмөрийн алдар” медалийг 20,000 /Хорин мянга/ төгрөг
 - Б/ Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагнал:
 - “Хурлын хүндэт тэмдэг”-ийг 30,000 /Гучин мянган/ төгрөг
 - “Хүндэт өргөмжлөл”- ийг 25,000 /Хорин таван мянга/ төгрөг

В/ Дүүргийн Засаг даргын шагнал:

“Өргөмжлөл”-ийг 10,000 /Арван мянган/ төгрөг

“Шилдэг хүүхэд” медалийг 15,000 /Арван таван мянган/ төгрөг

ДОЛОО. ШАГНАЛЫН МЭДЭЭЛЛИЙН САН БА ШАГНАЛ НӨХӨН ОЛГОХ

- 7.1. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Ажлын алба, Засаг даргын Тамгын газар нь шагнагдсан байгууллага, аж ахуйн нэгж, иргэний мэдээллийн сантай байна. Мэдээллийн санг шагналын асуудал хариуцсан мэргэжилтэн хариуцаж шагналын төрөл, олгосон хугацаа, оноор төрөлжүүлж, архивын ажлын үндсэн зааврын дагуу хадгаламжийн нэгж бүрдүүлэн архивлана.
- 7.2. Шагналыг үрэгдүүлсэн тохиолдолд нөхөн олгож болно.
 - 7.2.1. Нөхөн олгоход дараах материалыг бүрдүүлнэ.
 - а/ Шагналыг дахин олгохыг хүссэн өргөдөл
 - б/ Иргэний үнэмлэхийн хуулбар;
 - в/ Шагналын үнэмлэхийн хуулбар
 - г/ Төрийн сан банкны Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын дүүрэг хөгжүүлэх дансанд 10.000 /Арван мянга/ төгрөг тушаасан баримт.
 - 7.2.2. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Ажлын алба, Засаг даргын Тамгын газар нь шагнал нөхөн олгохыг хүссэн материалыг хүлээн авч, нөхөн олгох үндэслэлтэй гэж үзвэл иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг даргад танилцуулж шийдвэрлүүлнэ.